

АНАГААХ УХААНЫ ТӨВ НОМЫН САНГИЙН ХАМТ ОЛОН “НОМ НӨХӨН СЭЛБЭХ, СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ” ТӨСЛИЙГ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА

Удирдагчийн нэр: *Нямжавын Сүмбэрзул* / АШУҮИС-ийн Боловсролын асуудал эрхэлсэн тэргүүн дэд захирал, хүний их эмч, АУ-ны д-р, проф./

ЗОРИЛГО

Их дээд сургуулийн ном, сурах бичиг, гарын авлагыг тогтмол үзэж, байнга эргэлтэнд орж хэрэглэдэг тул ном гэмтэлд өртөх эрсдэл ихтэй байдаг. Номыг зөв зохистой хадгалан хамгаалах, аль болох олон уншигчдад хүртээх, номын эдэлгээг уртасгах ажлын нэг бол номыг нөхөн сэргээх, сэлбэн засах, засварлах ажиллагаа юм. Зах зээлийн жилүүдэд номын гэмтэл нь гадаад орчны нөлөөлөл(агаарын бохирдол, тоосжилт, бактери үүсэх, хорхой шавьжинд идэгдэх), ахуйн гэмтлээс (урагдах, хуудас дутуу, хавтаснаас салах, өнгө үзэмж муудах) гадна хэвлэх үйлдвэрээс шаардлага хангаагүй наалт муутай, оёдолгүй номууд нь хэвлэгдэн гарах болсон нь уншигчийн эрэлт хэрэгцээнд нийцэхгүй, удаан хугацаагаар ашиглах боломжгүй, заримдаа номын дотроос дэвтрийн хуудсууд хэсэг бүлгээр сугарч унадаг зөрчлүүд ихээр гарч, номыг гэмтэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах хэрэгцээ шаардлагатай байгааг үндэслэн Анагаах Ухааны Төв Номын Сангийн хамт олон “Ном нөхөн сэлбэх, сэргээн засварлах” төслийг амжилттай хэрэгжүүлж байна



Номын санчдад ном сэлбэн засах анхан шатны сургалт явуулж байгаа нь



Номонд бичил биетан агуулагдаж буй тодорхойлохоор сорьц авч байгаа нь

Төсөл хэрэгжсэнээр номын сангийн дэргэд “Ном сэлбэн засах” зориулалтын өрөөг шинээр бий болгон завсарлан тохижуулж, 16 нэр төрлийн тоног төхөөрөмж,

техник хэрэгслэлийг суурилуулан үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн ном сурах бичгийн эдэлгээ гэмтэл, сурах бичгийн хүрэлцээ, тоосжилтонд судалгаа хийсэн. Судалгаанаас үзэхэд оюутнууд номын сангаас авсан номыг ашиглахдаа зүй бус хэрэглэдэг, хуудас дээр тэмдэглэлээ хийх, эрээчих, номын зураг буулгахдаа номын зураг дээр давхарлаж зурдаг, хэрэгцээт хуудсыг урдаг, хуудсыг нугалдаг,

зэрэг нь номыг гэмтээж, эргэлтэнд орох боломжгүй болгодог байна. Мөн шинээр ирж буй зарим номын нурууны наалт муугаас дэлгэхэд амархан салдаг, будагны бэхжилт муугаас будаг гардаг, номын сан ном сурах бичгийг он удаан жилийн хугацаанд ариутгагдаж байгаагүй, гадуур эмнэлэгүүдээр авч явдаг учир янз бүрийн халдвар тээгч болох магадлалтай, тоосжилт ихтэй байна.

Төслийн хүрээнд одоогийн байдлаар 3500 гаруй номыг ариутгаж, урагдаж гэмтсэн ном сурах бичгийг сэлбэн засаж эргэлтэнд оруулаад байна.

